



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд нэмж гаргаж буй
энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 63 дугаар зүйлийн 63.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,941,457 /таван сая есөн зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун тавин долоо/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн, тус компанийн нийт гаргасан хувьцааг 6,000,000 /зургаан сая/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газарт үүрэг болгож, нэмж гаргаж буй энгийн хувьцааг үнэт цаас гаргагчийн тодорхойлсон хувьцаа эзэмшигчийн өмчлөлд зохих журмын дагуу бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Тэнгэрлиг медиа групп” ХК /Г.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН